



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/165

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар бүлгийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Түүх соёлын үл хөдлөх дурсгал”-ыг гэрээгээр хамгаалах журмын хүрээнд улсын хамгаалалтад байгаа дурсгалуудыг гэрээгээр хамгаалуулсан зардалд 4,000,000 төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 4,000,000 (Дөрвөн сая) төгрөгийг Засаг дарга данснаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батнасан), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Гомбосүрэн) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Сандагсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

8400001 2696

Zah A/165 Ba